

МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

С. Энхцэцэг*

Орос-Монголын улс төрийн харилцаанаас эдийн засгийн харилцаа мэдэгдэхүйц хоцорч түүнийг шийдвэрлэж чадахгүй хойшлуулсаар ирсэн тул ОХУ-ын Монгол дахь эдийн засгийн ашиг сонирхол ихээхэн суларч экспортын хэмжээ, гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо, оруулсан хөрөнгийн эргэлт зэргээрээ БНХАУ, Япон, БНСУ, АНУ-аас ихээхэн хоцорсон билээ. ОХУ-ын эдийн засаг өсч, их гүрний байр сууриа бэхжүүлэх сонирхол нэмэгдэхийн хэрээр үүндээ зохих дүгнэлт хийж хоёр орны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тодорхой бодлого, төсөл боловсруулж эрчимтэй ажил хэрэг болгон хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарч байна. Нөгөө талаас хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлж шинэ шатанд гаргах улс төр, эдийн засгийн нөхцлүүд бүрдэж улам бүр тааламжтай болсон нь өнгөрсөн хугацаанд /18 жил/ дэлхийн эдийн засаг, бүс нутгийн төлөв байдал өөрчлөгдсөнөөр хоёр талын эдийн засгийн ашиг сонирхол харилцан нөхцөлдөж байгаатай ч бас холбоотой юм. Тухайлбал 1990-ээд оны эхэн үеэс Монгол, ОХУ хоёул хөгжлийнхөө хуучин стратеги бодлогыг өөрчилж, зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжиж гадаад худалдааны улсын монополийг халж, чөлөөт худалдаа хөгжүүлэх болсон нь хоёр улсын хоорондын харилцаа шинэ шатанд хөгжих үндсэн нөхцлийг бүрдүүлэв.

1993 онд гарын үсэг зурсан Монгол ба ОХУ-ын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ, 1996 оны гэрээгээр тунхагласан социалист интернационализмын баримтлал болон цэргийн холбооны үүргээс татгалзаж түгээмэл ардчилсан зарчмыг баримтлах болсноороо цэрэг, улс төрийн асуудлаас ангид байх бололцоотой болсон юм.

1994 онд батлагдсан Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд ОХУ-тай үйлдвэр, худалдааны салбарт явуулж байгаа хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд эрчимжсэн манай хоёр орны төр, засгийн удирдлагуудын өндөр хэмжээний айлчлалууд нь Монгол-Оросын эдийн засаг, худалдаа, нийгмийн хүрээн дэх хамтын ажиллагааг өргөжүүлэн шинэ шатанд гаргах бодит алхам боллоо. Энэ хүрээнд хоёр талын харилцааны эрх зүйн асуудлыг боловсронгуй болгох, хамтарсан үйлдвэр, аж ахуйн байгууллагын үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, худалдааг либералчлах, хөдөө аж ахуйн болон боловсруулах салбарт хамтран ажиллах, соёл, боловсрол,

* МУИС, ОУХС-ийн багш, докторант

хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг асуудлууд хөндөгдөж байв.

Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрш орнуудтай сайн хөршийн найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг уламжлал, итгэлцэлд тулгуурлан өргөтгөн хөгжүүлэхийг эрхэмлэж “ОХУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш харилцан ашигтай хамтын ажиллагааг Монгол улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний заалт, үзэл санааны дагуу бүх салбар чиглэлээр өргөтгөн хөгжүүлж, хуримтлагдсан асуудлуудыг зохистой шийдвэрлэнэ” гэж тусгайлан заасан нь манай улсын зүгээс ОХУ-тай харилцах харилцаанд ихээхэн ач холбогдол өгдгийн илрэл юм.

2000 онд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины Монгол дахь айлчлалын үеэр “Улаанбаатарын тунхаглал”-д гарын үсэг зурж, хоёр орны харилцааны тухайн үеийн нөхцөл байдлыг тал бүрээс нь үнэлэн цэгнэж, шинэ ХХI зууны хамтын ажиллагааны чиглэл, агуулга, төлвийг олон улсын харилцааны цар хүрээ, нийтлэг хандлагатай холбон тодорхойлсон нь онцгой чухал ач холбогдолтой байв. В.В.Путин айлчлалын үеэрээ “Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд танай орон онцгой байр суурь эзэлдэг” гэж цохон тэмдэглэсэн нь хоёр талын харилцаанд тогтож байсан хүйтэн уур амьсгалыг дулаануулсан гэж үзэх үндэстэй юм. Улаанбаатарын тунхаглалд Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх үүднээс худалдааг чөлөөтэй болгон хөгжүүлэх, түүний дотор төмөр замын тээврийн тариф, гаалийн татвар, бусад хураамжийг хөнгөлөлттэйгээр тогтоох асуудлыг 2000 онд багтаан шийдвэрлэхийг холбогдох байгууллагуудад даалгаж, Монгол-Оросын хамтарсан томоохон үйлдвэрүүдийг шинэчлэн тоноглох, хамтарсан үйлдвэрүүдийг шинээр байгуулах, Монголын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтын ажиллагааг сэргээх, бүс нутгийн болон хил орчмын харилцааг өргөтгөн гүнзгийрүүлэхээр тохиролцож Зүүн хойт Азийн эрчим хүчний томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол улс оролцохыг Оросын тал дэмжиж байгаагаа илэрхийлж байв.

Монгол улс, ОХУ-ын хооронд он дамнан яригдсаар ирсэн “их өрийн” асуудлыг 2003 онд эцэслэн шийдвэрлэсэн нь хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаа улам бүр эрчимтэй хөгжих нөхцлийг бүрдүүлэв. Монгол улсын хувьд дарамт болж байсан “их өр”-ийн асуудлыг шийдвэрлэснээр олон улсын зэрэглэл тогтоох Фич, Мүүдиз, Стандарт анд Пүэрс байгууллагуудаас манай орны зээлжих зэрэглэлийг +В болгон дээшлүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нааштай нөлөө үзүүлж байна. Мөн шууд хөрөнгө оруулалт болон гадаад худалдааг хөгжүүлэх, өргөжүүлэх нэн таатай нөхцөл шинээр бүрдүүлж байгаа нь сүүлийн жилүүдэд хийгдэж буй өндөр хэмжээний тогтмол айлчлалуудаас харагдаж байна.

ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины урилгаар Монгол улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр 2006 оны 12 сард ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Хоёр улсын төрийн тэргүүний айлчлалын хүрээнд Орос, Монгол хоёр улсын харилцаа уламжлалт, *сайн хөршийн түншлэлийн* гэсэн томъёоллоос *стратегийн түншлэл* болж өргөжсөнөөрөө бас нэг ач холбогдолтойд тооцогдох болсон юм. Айлчлалын үеэр:

- Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол улс, ОХУ хоорондын гэрээ;

- Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөр;
- Төмөр замын тээврийн салбарт хамтран ажиллах тухай Монгол улсын ЗТАЖЯ, ОХУ-ын Тээврийн яам хоорондын харилцан ойлголцлын тухай санамж бичиг¹ зэрэг томоохон баримт бичгүүдэд гарын үсэг

зурсан нь цаашид хоёр улсын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэн хөгжүүлэх нэг чухал алхам болов.

Уг айлчлалын үеэр хоёр орны худалдааны эргэлтийг 2010 он гэхэд 1 тэрбум ам.долларт хүргэх, ОХУ-ын талаас Монголд 3-5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх бололцоотой хэмээн тодорхой тоогоор илэрхийлэгдсэн бодит асуудлыг хөндөн ярилцсан нь хоёр улсын хоорондын бизнес эрхлэгчдэд ихээхэн итгэл найдвар төрүүлсэн чухал алхам болсон юм. Хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцаа харилцан бие биеэ нөхдөг бөгөөд цаашид хөгжүүлэх өргөн боломжтойг талууд хүлээн зөвшөөрч эдийн засгийн төрөл бүрийн салбар, ялангуяа түлш, эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрлэл, тээврийн болон ХАА-н салбар, түүнчлэн санхүү, банкны бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд өргөнөөр хоршин хамтран ажиллах эрмэлзлэлтэй байгаагаа талууд хүлээн зөвшөөрсөн билээ. Хоёр талын худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, харилцан хөрөнгө оруулах таатай нөхцлийг бүрдүүлж, түүнийг хоёр орны үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хамгаалах баталгаагаа гаргахад хамтарсан хүчин чармайлт тавихаа харилцан тохиролцов.

2007 оны 12 сард ОХУ-ын ерөнхийлөгчийн тусгай төлөөлөгч, ОХУ-ын ХАА-н яамны сайд А.В.Гордеев бизнес болон төр, засгийн байгууллагын 200 орчим төлөөлөгчийг тэргүүлэн ирж “Монгол-Оросын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдвийн дор болсон хоёр орны бизнес форумд оролцов. Уг форумын үеэр хоёр улсын хил орчмын худалдаа, эдийн засаг, төмөрлөгийн болон уул уурхайн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал нилээд түлхүү яригдав. Тухайн үед Оросын талын төлөөлөгчид манай улс **зээлдэгч биш санхүүжүүлэгч орон** болсон гээд уул уурхайн салбар, ялангуяа төмөр, нүүрс, зэс, уран, түлш эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах, хил орчмын худалдааг өргөжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлж байв.

Монгол улсын засгийн газрын тэргүүн С.Баяр ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр (2008 оны 4 сард) хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх асуудлаар ярилцаж, олон улсын орчин үеийн стандарт, эдийн засгийн бодит байдлын дагуу эдийн засгийн төрөл бүрийн салбар, ялангуяа түлш эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрлэл, тээврийн болон хөдөө аж ахуйн салбар, түүнчлэн санхүү банкны бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хамтарсан төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллах шаардлагатайг талууд хүлээн зөвшөөрсөн нь төрийн тэргүүнүүдийн айлчлалын үр дүн бодит байдал дээр хэрэгжиж эхэлсний илрэл байв. Хоёр талын худалдаа, эдийн засаг, бизнесийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтарсан үйлдвэрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, техник технологийг шинэчлэн сайжруулах, атомын эрчим хүчийг энхийн зорилгоор хамтран ашиглах, хил орчмын худалдааг өргөтгөх зэрэг томоохон асуудлуудыг уг уулзалтаар хөндөж ярилцсан байна.²

¹ Зууны мэдээ сонин 2006 оны 12 сарын 12. № 259(2431)

² www.zuuniimedee.mn (2008 оны 4 сарын 14)

1990 оноос хойш өнөөг хүртэл хугацаанд хоёр улсын хамтын ажиллагааг зохицуулах механизмын хүрээнд бүс нутаг, хамтын ажиллагааны дэд комисс, худалдааг либералчлах ажлын хэсэг, тээвэр болон эрчим хүчний ажлын хэсэг, үл хөдлөх хөрөнгийн ажлын хэсэг зэрэг 10 гаруй комисс байгуулагдсан байна. Мөн хоёр улсын хамтын ажиллагааг хөгжүүлэн шинэ түвшинд гаргах үүднээс 2010 он хүртэлх худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулжээ.

Улс төр, эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа ч хоёр улсын харилцаанд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна. 1992 онд Монголын талын хүсэлтээр визтэй зорчих болсон нь хоёр орны хооронд чөлөөт худалдаа эрхлэх боломжийг хязгаарлах болсон юм. 2006 онд Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Москвад хийсэн айлчлалынхаа үеэр хоёр орны хооронд зорчих визийн асуудлыг хөнгөвчлөх хүсэлтэй байгаагаа илэрхийлсний хариуд Оросын тал үе шаттайгаар богино хугацаанд шийдэхээ амласан боловч өнөөг хүртэл тодорхой ажлууд хийгдээгүй л байна. Жижиг, эмзэг эдийн засагтай Монгол улсын хувьд өндөр өртөгтэй бензин шатахуун худалдан авдаг нь ард түмний амьдралд ихээхэн дарамт учруулдаг тул дотооддоо газрын тосны үйлдвэр байгуулж ОХУ-ын үйлдвэрлэдэг, олборлодог компаниудтай шууд холбоо тогтоон худалдан авах сонирхолтой байгаагаа дээрх айлчлалуудын үеэр удаа дараа илэрхийлж байсан боловч дорвитой шийдэлд хүрсэнгүй.

Дэлхийн эдийн засагт жинтэй байр суурь эзэлдэг хоёр том их гүрний дунд нь орших стратегийн байршил маань монголчууд бидэнд хөгжиж дэвших өргөн боломжийг олгох болсон өнөө үед умард хөрш ОХУ-тай хийж буй худалдаа, хөрөнгө оруулалт ямар байгааг тодруулан авч үзье.

1. Монгол дахь ОХУ-ын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал

Монгол улсын засгийн газар ОХУ-ын засгийн газартай 1995 онд “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд давхар татварын гэрээ нь 1998 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон байна.

Оросын Монгол дахь хөрөнгө оруулалт, худалдаа нь ЗХУ-ын үеийн монополь байр сууриа алдсан боловч гурван том хамтарсан үйлдвэрийн (Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, Монголросцветмет нэгдэл, “Улаанбаатар” төмөр зам) нийт бүтээгдэхүүн Монгол улсын ДНБ-ний 40 хувь, тэдгээр бүтээгдэхүүний экспорт нь нийт экспортын 60 хувийг эзэлж байна. ОХУ-нь Монгол улсын эдийн засагт голлох аж үйлдвэр, тухайлбал, эрчим хүч нийлүүлэх, төмөр зам, уул уурхай зэрэг салбаруудад нилээд их хэмжээгээр нөлөөтэй байгааг дээрх үзүүлэлтүүд илэрхийлж байгаа тул ОХУ-ын Монгол дахь нөлөөг үгүйсгэх аргагүй юм.

1991 оноос ОХУ-ын бизнес эрхлэгчид Монголд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд 1993 онд 261 мянган ам.доллар, 2001 онд 5.7 сая ам.доллар, 2005 онд 7450 сая ам.долларт хүрсэн байна. Хөрөнгө оруулах сонирхолтой компанийн тоо байнга өссөн байдлаас үзвэл ОХУ-ын хөрөнгө оруулагчид Монголын зах зээлийг сонирхож байна гэж дүгнэж болох юм. 2006 онд нийт 502 компани бүртгүүлсэн бөгөөд нийтдээ 56 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулсан нь

Монголд орсон нийт гадаадын хөрөнгө оруулалтын 3,1 орчим хувийг эзэлж байна.


Хүснэгт № 1

Он	1991	1993	1997	2004	2005	2006
Бүртгүүлсэн Компанийн тоо	5	9	33	45	59	502

1990-2005 онуудад Орос улсаас Монгол улсын эдийн засгийн 18 салбарт нийт 40 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулсны 27,2 хувь геологи хайгуулын салбарт, 15,5 хувийг барилга болон барилгын материалын үйлдвэрлэл, 12,3 хувь санхүүгийн байгууллага, 9,7 хувь хүнсний үйлдвэр, 6,5 хувь тээвэр, 6,3 хувь худалдаа, үйлчилгээний салбарт тус тус оруулсан байна. 2006 онд Монгол улсад Оросын 100 хувийн буюу хэсэгчилсэн хөрөнгө оруулалттай 430 гаруй хамтарсан үйлдвэр ажиллаж байна.³

Зураг №1

Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалт /орнуудаар, 2006 он/



Монгол дахь нийт хөрөнгө оруулалтын 3 хувийг ОХУ, БНХАУ 47 орчим хувийг эзэлж байгаа нь хоёр хөрш оронтой тэнцвэртэйгээр харилцаж аюулгүй байдлаа хангах Монгол улсын үндэсний ашиг сонирхолтой зөрчилдөж байгаа юм. Тиймээс хөрөнгө оруулалтын тэнцвэрт харилцааг хангахын тулд Оросоос оруулж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

ОХУ нь бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ 6 дугаарт /45.8 сая ам.доллар/, компанийн тоогоороо 3 дугаарт /502/ орж байна. ОХУ-аас уул уурхай /17 сая ам.доллар/, барилга байгууламж, барилгын материалын

³ В.Грайворонский: "Орчин үеийн Монгол улсын талаарх Орос улсын баримталж буй бодлогын зарим онцлог" Стратеги судлал. №40 (4/2007) х.126

үйлдвэрлэл /5.3 сая ам.доллар/, банк санхүү /4.1 сая ам.доллар/ (Чингис хаан банк), хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл /4.1 сая ам.доллар/ зэрэг салбаруудад түлхүү хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбар нийт хөрөнгө оруулалтын 26.4 хувийг эзэлж байна. Барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт ч мөн адил томоохон хөрөнгө оруулагч бөгөөд салбарын хөрөнгө оруулалтын 9.5 хувийг эзэлжээ.

Форбес болон Финанс сэтгүүлээс зарласан дэлхийн баячуудын нилээд нь газрын баялаг, ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулдаг оросууд байх болсон төдийгүй тэдгээрийн зарим нь Монголд бизнесээ тэлж, хөрөнгө оруулалт хийх сонирхолтой ажээ. 2006 онд Монгол улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр Москвад айлчлах үеэр ОХУ-ын төрийн тэргүүн В.В.Путин: “Манай улс Монголд 5 тэрбум хүртэл ам.долларын хөрөнгө оруулалт хийх боломжтой” хэмээн мэдэгдэж, зарим баячууд Монголд хөрөнгө оруулалт хийх сонирхолтойгоо илэрхийлж байсан нь ОХУ-ын бизнесийн бодит сонирхол манай улс руу чиглэснийг илүү тодорхой харуулна. Уг айлчлалын үеэр нийт хөрөнгө нь 14,4 тэрбум ам.долларт эргэлддэг, мөнгөний олборлолтоороо ОХУ-д 1, дэлхийд 5-рт, алт олборлолтоороо ОХУ-д 2 ордог “Полиметалл” Асгатын мөнгөний ордыг хамтран ашиглах сонирхолтой байгаагаа “Монголросцветмет” компанид тавьсан байна. 2006 онд дээрх хоёр компани “Асгат”-ын мөнгөний орд газрыг хамтран ашиглахаар гэрээ байгуулсан боловч Монгол улсын Засгийн газраас уг гэрээг хууль зөрчсөн хэмээн үзэж цуцалсан юм.

ОХУ-ын тэргүүн баян хэмээгдэх болсон “Базовый элемент” компанийн эзэн Олег Дерипаскагийн “Үлдсэн элемент” компани, “Северсталь” компанийн тэргүүн А.Мордашов нар “Тавантолгой” орд газрыг, “Инеррос” холдингийн эзэн В.Потанин нүүрс, уран, жонш олборлох сонирхолтой төдийгүй “Таван толгой”-н ордыг, 5,9 тэрбум долларын хөрөнгө эзэмшдэг ТНК-ВР группийн захирал Виктор Вексельберг Дорнод аймаг дахь ураны ордыг сонирхож буйгаа тус тус илэрхийлжээ.⁴ Мөн Монгол улстай хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа “Зарубежгеология”, “Металлинвест”, “Внешторгбанк”, “Норильский никель” зэрэг компаниуд орж байна.⁵ Эдгээрээс О.Дерипаскагийн “Базовый элемент” компани Монголд төлөөлөгчийн газраа 2006 оны 11 сард нээхээ мэдэгдсэн бөгөөд түүний эзэмшилд уул уурхайн салбарт 35 орчим лиценз эзэмшдэг “Бату майнинг” компанийн 30 хувь, Плехановын нэрэмжит их сургуулийн салбар 100 хувь, 15-р микрорайон дахь орос хотхон, Кредит банк, Тээвэр хөгжлийн банк зэргээс гадна хуучин С.Громовын эзэмшилд байсан “АПУ” компанийн 43 хувь, “Монголдаатгал компани”, Дарханы махкомбинат, “Чингис хаан” банк зэрэг орж байгаа бөгөөд энэ бүхнийг нэгтгэж үзвэл түүний гарт Монголын банк, санхүүгийн салбарын 35 хувь төвлөрсөн байна.⁶

Оросын томоохон баячууд ийнхүү манай улсыг сонирхож байгаа нь их хэмжээний байгалийн нөөц баялгаас гадна орд газрыг эзэмших, ашиглах лиценз гаргах урсгал зардал нь ОХУ-д ижил төрлийн бизнес эрхлэхээс хэд дахин хямд байдагтай холбоотой ажээ. Оросын мэргэжилтэн, геологичид манай улсын ашигт малтмалын байршил, нөөц, гадаадад борлуулах эрэлт хэрэгцээг эртнээс сайн

⁴ Өнөөдөр сонин 2007 оны 3 сарын 23., №068 (3026)

⁵ Өнөөдөр 2006 оны 12 сарын 2. № 256 (2910)

⁶ Ардын эрх сонин. 2008 оны 1 сарын 7. №003/791

мэдэх тул хөрөнгө оруулах, хамтарсан үйлдвэр байгуулах зэргээр хамтран ажиллахад давуу талтай.

Монгол, Оросын хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд

Монгол дахь Оросын буюу Орос-Монголын хамтарсан аж ахуйн газар 150 орчим ажиллаж байсан боловч тэдгээрийн хөрөнгө оруулалтын хэмжээнд өнөөг хүртэл дорвитой өөрчлөлт гараагүй байна. Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр гэхэд дангаараа 2006 оны байдлаар улсын төсвийн 31,4 хувь, гадаад худалдааны эргэлтийн 26,6 хувь, ДНБ-ний 10,1 хувийг бүрдүүлжээ.⁷ Нийт хоёр талын хамтарсан үйлдвэрүүдэд 11 мянга орчим ажиллагсад ажиллаж байгаа бөгөөд Эрдэнэт, Бор-Өндөр, Зүлэгт, Толгойт зэрэг уурхайчдын хотуудыг хамтарсан үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулжээ. Эдгээр хот, тосгодын нийгэм ахуйн болон дулаан, цахилгааны зардлын нилээд хэсгийг хамтарсан үйлдвэрүүд санхүүжүүлдэг байна.

“Монголросцветмет” нэгдлийн бүрэлдэхүүнд Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Өргөн, Хар-Айраг, Хажуу-Улааны хайлуур жонш олборлох ил уурхайнууд, Хашаат худгийн нүүрсний ил уурхай ордог юм. Монголросцветмет” нэгдэл хайлуур жоншны хүдэр олборлон баяжуулж 92% ба 75%-ийн агуулгатай үндсэн хоёр төрлийн баяжмалыг ОХУ ба ТУХН-ийн орнуудад экспортлодог бөгөөд Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварын хөнгөлөлт эдэлдэг юм.

Монгол улсын ерөнхий сайд С.Баярын ОХУ-д хийсэн албан айлчлалын үеэр хоёр улсын хамтарсан “Улаанбаатар төмөр зам”-ыг техникийн хувьд шинэчлэх, бүс нутагт байнга өсөн нэмэгдэж буй төмөр замын тээврийн эрэлт хэрэгцээг хангахуйц хүчин чадалтай болгох асуудлаар хоёр тал тохиролцоонд хүрчээ. “УБТЗ” хууль эрх зүй, техник технологийн хувьд шинэчлэгдэхээр болсон төдийгүй Оросын талын төлөөлөл солигдож “Оросын төмөр зам” хэмээх төрийн өмчит компани хууль ёсны эрхийг шилжүүлэн авснаар хөрөнгө оруулалт нэмэгдэх, техник технологийн хувьд шинэчлэгдэхээр болжээ.

“Чингис хаан”, “Хадгаламж” банк, Монголдаатгал компани Оросын хөрөнгө оруулалттай болсон билээ. ОХУ-ын хувь нийлүүлсэн төрийн өмчит “Россельхоз” банк “Голомт” банкаар дамжуулан 200 сая ам.долларын зээлийг манай улсын газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, адил төстэй нөхцөлтэй бүс нутгаас үр, бордоо нийлүүлэх г.м. ХАА, үйлдвэрлэлийг дэмжихэд зориулахаар болсон нь манай “Атрын III аян” хөтөлбөрийн хэрэгжилтэнд үр дүнгээ өгөх томоохон алхам болжээ.

ОХУ-ын “Росатом” корпораци, Монгол улстай хамтран “Уран болон дагалдах ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын салбарт хамтын ажиллагааг хөгжүүлж, хамтарсан үйлдвэр байгуулах” тухай протокол байгуулжээ. Энэ ажлын үр дүнд Монгол улсад дунд хэмжээний хүчин чадалтай Атомын цахилгаан станц барих, ураныг зөвхөн олборлоод зогсохгүй боловсруулах үйлдвэрийг Монгол, Оросын аль алины нутаг дэвсгэрт байгуулахаар болжээ. Энэхүү ажлын хүрээнд эрдэс баялаг, уул уурхайн салбар ялангуяа ураны олборлолт, боловсруулалтын чиглэлээр монгол мэргэжилтэн ОХУ-д бэлтгэхээр тохиролцсон байна.

⁷ www.erdenetmc.mn

2. Монгол, Оросын худалдааны харилцаа

Монгол улсын гадаад худалдаа эрчимтэй өсч байгаа хэдий ч цөөн хэдхэн улсаас эдгээрийн дотор хоёр хөрш болох ОХУ, БНХАУ-аас үлэмж хамааралтай, экспортын барааны олон улсын зах зээлийн үнийн хэлбэлзэл (үүн дотор алт, зэс, ноос ноолуурын үнэ) мөн байгаль цаг агаарын байдлаас ихээхэн шалтгаалж өөрчлөгддөг сул талтай. 2006 онд В.В.Путин, Н.Энхбаяр нар Москвад уулзахдаа 2010 он гэхэд хоёр улсын гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээг 1 тэрбум ам долларт хүргэхээр тохиролцсон билээ. Үүний үр дүнд хоёр орны хоорондын худалдааны эргэлтийн хэмжээ 2007 оны эхний хагас жилд өсч 730,1 сая ам.долларт хүрсэн нь 2000 онтой харьцуулахад 467,3 сая ам доллароор, 2005 онтой харьцуулахад 278,1 ам.доллароор тус тус нэмэгджээ. Гэвч экспорт хоёр, импорт гурван оронтой тоонд эргэлдэж хоорондын харьцаа хэт их ялгаатай байгаа нь ОХУ-тай хийж буй манай улсын худалдааны тэнцэл ихээхэн алдагдалтай байгааг харуулж байна.

Хүснэгт №2

Монгол улс, ОХУ-ын худалдааны тэнцэл /1997-2007/⁸

Он	Импорт	Экспорт	Нийт дүн	Зөрүү	Нийт худалдааны эргэлтэнд эзлэх хувь
1997	212,5	46,6	259,1	-165,9	23,1%
1998	190,8	40,5	231,3	-190,3	22,4%
1999	198,0	48,2	246,2	-149,8	22,7%
2000	224,5	38,3	262,8	-186,2	22,3%
2001	241,5	39,6	281,1	-201,9	25,6%
2002	267,6	43,0	310,6	-224,6	23,0%
2003	294,5	37,5	332,0	-332,0	21,2%
2004	354,6	18,0	372,6	-336,6	18,9%
2005	426,0	26,0	452,0	-400,0	19,3%
2006	590,0	44,7	634,7	-545,3	19,5%
2007*	683,9	46,2	730,1	-637,7	19,4%
Монгол улсаас ОХУ-д төлөх урсгал өр /энэ хугацаанд/				1,183 сая \$	

ОХУ-тай хийж буй худалдааны алдагдал тогтмол өсч байгаа нь Монгол улсаас Орост гаргадаг экспортын хэмжээ буурсаар байгаа, нөгөө талаас Оросоос Монголд нийлүүлдэг гол бүтээгдэхүүн болох газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ эрс өссөнтэй холбоотой юм. 1997-2007 оны хооронд 10 жилийн хугацаанд ОХУ-ын манай улсаас авах авлага 1 тэрбум 183 сая ам.доллараас өсчээ. Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2000 онд нийт экспортод 35,2 хувийг, 2004 онд 40,7 хувийг эзэлж байсан бол 2007 онд 66,8 хувийг эзлэх болсон байна. 2005 онд нийт экспортын 14,5 хувийг түүхий эд эзэлж байсан бол 2006 онд энэ нь 12 хувь, 2007 онд 9,8 хувь болсныг үзвэл экспортын бүтцэд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувь нэмэгдэх төлөвтэй байна.

⁸ Монгол улсын статистикийн эмхэтгэлээс, 1997-2007

* Тухайн оны 11 сарын байдлаар

Доорх зургаас үзэхэд сүүлийн 10 жилд Монгол улсаас ОХУ-д гарч буй экспорт хэвэндээ, харин Оросоос авч буй импорт 3 дахин өсчээ. ОХУ-д ногдож буй экспорт Монгол улсын нийт экспортын 2,5 хувийг эзэлж байгаа нь манай худалдааны хоёр дахь том түнш гэхэд ихээхэн чамлалттай үзүүлэлт юм. Хэдийгээр хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх талаар дээд хэмжээний айлчлалуудын түвшинд нухацтай ярилцаж харилцан зөвшилцөлд хүрч байгаа ч дунд, доод шатан дахь үйл ажиллагаа сайн хэрэгжихгүй байгаагаас эдийн засгийн хамтын ажиллагаа санасан үр дүнд хүрэхгүй байна гэж төрийн тэргүүнүүдийн уулзалтаар дүгнэсэн нь үнэний хувьтай байгааг дээрх үзүүлэлтүүд харуулж байна.

Зураг №2



Хилийн худалдаа

ОХУ-ын Буриад, Тува, Алтай зэрэг Бүгд найрамдах улсууд болон Эрхүү, Чита болон Сибирийн зарим мужуудтай ойр дотны харилцаатай ажиллаж байна. Газар зүйн нэн ашигтай байршилтай, эртний гарал үүсэл, хэл соёл, шашин нэгтэй үндэстнүүд хилийн дагуу оршин суудаг зэрэг нь хоёр орны худалдааг хөгжүүлэх таатай нөхцөл учраас хил орчмын худалдааг улам эрчимжүүлэх явдал бараа таваарыг шуурхай бөгөөд хямдаар арилжаалах давуу талыг олгож байна. Хоёр улсын засгийн газрын комиссын хүрээнд бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг эрхэлсэн дэд комиссыг 1996 онд байгуулсан явдал нааштай алхам болсон байна. Үүнд: Буриад улсын ерөнхийлөгч, Эрхүү ба Кемерово мужийн амбан захирагч нар Монголд айлчилж холбогдох хэлэлцээр байгуулан бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

2006 оны Москвад болсон дээд хэмжээний уулзалтын үеэр хоёр орны бүс нутгийн харилцаа холбоо, хил орчмын хамтын ажиллагаа, худалдааг хөгжүүлэн дэмжих зорилгоор хил орчмын дэд бүтцийг сайжруулан хөгжүүлэх, хоёр улсын иргэд харилцан зорчих дэг журмыг хөнгөвчлөх, дэлхийн эдийн засаг дахь интеграцийн үйл явцын үр дүнд нээгдэж байгаа шинэ боломжуудыг харилцан ашигтайгаар ашиглахын төлөө байгаагаа харилцан илэрхийлж байв.

Хоёр улсын хил орчмын болон ойр бүс нутгийн хоорондын худалдаа нь Монгол, Оросын худалдааны нийт эргэлийн 70 гаруй хувийг эзэлж байна. Үүнд Оросын талаас голчлон Эрхүүгийн муж, Бүгд найрамдах Буриад улс, Алтай

хязгаар, Читийн муж, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Алтай улс зэрэг болно.⁹ Улаанбаатар хотод Иркутск, Улаан-Үдийн худалдааны төлөөлөгчийн газар нээгдэн үйл ажиллагаа явуулах болсон нь хоёр талын бизнес эрхлэгчдийн дунд ажил хэргийн холбоо тогтоох чухал алхам болжээ. Мөн Эрхүү мужид Монгол, Оросын хамтарсан үйлдвэр байгуулах, зарим аж ахуйн нэгжүүд төлөөлөгчийн газраа нээх хандлага нэмэгдэж байна. Одоогийн байдлаар тэнд 108,0 мянган рублийн дүрмийн сан бүхий 8 хамтарсан аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Монгол, Оросын хамтарсан “Монголросцветмет” нэгдэл 2006 оны 12 дугаар сараас төлөөлөгчийн газраа нээн ажиллуулж байна. Европоос Зүүн өмнөд Азийн орнуудад, цаашлаад АНУ руу тээвэрлэх барааны эргэлтийг сайжруулах зорилгоор Орос-Монгол-Белоруссийн хамтарсан “Монгол вектор” төсөл хэрэгжиж байгаа ажээ. Хэрэв уг төсөл амжилттай хэрэгжвэл томоохон аж ахуйн нэгжийн барааг 9 хоногийн дотор Оросын төмөр замаар Брестээс Наушки хүртэл тээвэрлэж бараа эргэлтийг түргэсгэх боломжтой болох юм.

Экспортыг нэмэгдүүлэх, бүс нутаг, хил худалдааг хөгжүүлэх зорилтын үүднээс Алтанбулаг худалдааны чөлөөт бүс байгуулах чиглэлээр бэлтгэл ажил хийж байна. Түүнчлэн Монголын бүтээгдэхүүнд ОХУ-ын талаас ноогдуулж буй импортын татварыг бууруулах, тээврийн тарифыг хөнгөлөх, тарифын бус саад тогторыг арилгах талаар хэлэлцэж байна. 2006 онд Монгол улс Эрхүү муж хооронд хийсэн бараа эргэлтийн нийт хэмжээ 300 сая ам.долларт хүрч 2005 оныхоос 19,9 хувиар өссөн байна. Үүнээс импорт 279 сая ам.доллар, экспорт 21 сая ам.доллар байна. Импортын 90 орчим хувийг шатах, тослох материал экспортын дийлэнх хувийг мах, махан бүтээгдэхүүн эзэлжээ.

ОХУ ДХБ-д гишүүнээр элссэнээр хоёр талын худалдаанд үзүүлэх нөлөө

ОХУ ДХБ-д нэгдэн орох асуудалд манай улс ач холбогдол өгдөг. ОХУ ДХБ-д нэгдэн орох хэлэлцээгээ 1995 оноос эхэлсэн бөгөөд ДХБ-ын гишүүн 50 гаруй улстай тарифын болон үйлчилгээний худалдааны асуудлаар хэлэлцээ хийж байна. ДХБ-д элсэх асуудал ОХУ-ын хувьд хойшлуулшгүй зорилтуудын нэг ажээ. Учир нь ОХУ демпингийн эсрэг шинжтэй төрөл бүрийн санкцуудаас жил бүр 1 тэрбум орчим ам.доллар алдсаар байна.¹⁰ ОХУ ДХБ-ын гишүүн орнуудад барааны тарифын саналаа 1997 онд, үйлчилгээний худалдааны асуудлаарх үүрэг, амлалтын саналаа 1999 оны сүүлчээр өгсөн тул тодорхой яриа хэлэлцээ үндсэндээ сүүлийн 9 жил явагдаж байна. Монгол улс ОХУ-тай ДХБ-ын хүрээнд 1999 оны 10 дугаар сараас албан ёсны хэлэлцээ хийж эхэлжээ.

Монгол улс, ОХУ-ын хоорондын худалдааны балансын зөрүү нь ОХУ-д мөрдөгдөж байгаа импортын өндөр татвараас зохих хэмжээгээр хамааралтай байдгийг Монгол-Оросын ЗГХК-ын 1999 оны ҮII хуралдааны Протоколд тэмдэглэж, хоёр орны хоорондын худалдааг либералчлах хамтарсан ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэсний дагуу Монгол, Оросын худалдааг либералчлах ажлын хэсэг, энэ хугацаанд 5 удаагийн хэлэлцээ, зөвлөлдөөн хийсэн байна. Уг хэлэлцээний хүрээнд ОХУ-аас импортолж байгаа газрын тосны бүтээгдэхүүн, эрчим хүч, Монголын экспортын бараанд үйлчилж байгаа болон ОХУ-ын нутгаар дамжин өнгөрч буй ачааны тээврийн тариф, ОХУ-ын хилээр

⁹ Мөн тэнд. х.127

¹⁰ К.Дэмбэрэл. Оросын гадаад бодлого ба бизнесийн хүрээнийхэн” Олон улс судлал сэтгүүлийн 2006 оны дугаар №4 х.33

зорчигч болон бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд гаалийн журмыг хөнгөвчлөх асуудлаар голчлон ярилцаж байгаа юм. Манай улсын зүгээс Оросын талтай хэлэлцээ хийх шаардлагатай гэж үзсэн экспортын 21 нэрийн барааны жагсаалтыг хүргүүлжээ. Үүнд: ОХУ талд импортын татвараа мах, махан бүтээгдэхүүнд 6.3-3.1 хувь, арьс, ширэн болон үслэг, нэхий эдлэлд 5-3 хувь, хивсэнд 3 хувь, оёмол, сүлжмэл, ноолууран эдлэлд 5-3 хувь болгон бууруулах, жонш, зэсийн баяжмал, молибденийн хүдэр, баяжмалыг татваргүй болгох санал тавьсаны үр дүнд 2001 онд ОХУ-ын импортын татварыг мах, махан бүтээгдэхүүн, эрдсийн бүтээгдэхүүнд 25 хувиар бууруулжээ. Монголын талаас ОХУ-д бүтээгдэхүүн гаргахад импортын татвар өндөр, тээвэрлэлтийн төлбөр үнэтэй байгаагаа харилцан ярилцаж хоёр талын зүгээс хэлэлцэж шийдэх боломж байвал шийдэх эсвэл Европын эдийн засгийн холбоо, ДХБ-ын хүрээнд судалж болох юм гэж Монгол улсын ерөнхийлөгч Н.Энхбаярын 2006 онд ОХУ-д хийсэн айлчлалын үеэр тохирсон байна.

ОХУ-аас импортолж байгаа цахилгаан, эрчим хүчний тарифыг бууруулах, хоёр орны хооронд тодорхой нэр төрлийн бараагаар чөлөөт худалдааны тогтолцоо бий болгох асуудлыг судлах, Монголын мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд тавьж буй мал эмнэлгийн шаардлагыг зөөлрүүлэх, ОХУ-ын нутгаар тээвэрлэж байгаа манай экспорт, импортын болон транзит барааны төмөр замын тээврийн тарифыг бууруулах талаар яриа хэлэлцээгээ цаашид үргэлжлүүлэх юм.

ОХУ ДХБ-ийн гишүүн болсноор манай гадаад худалдаанд үзүүлэх эерэг тал гэвэл ОХУ-ын зах зээл нээлттэй болж, худалдааны элдэв хязгаарлалт багасч татвар, зардал буурах төдийгүй ноос, ноолуур, арьс ширэн эдлэл, мах, махан бүтээгдэхүүнийг ОХУ-ын зах зээл дээр худалдаалах боломж нээгдэх юм. Ингэснээр манай улсын гадаад худалдааны алдагдал багасч “бага өр”-ийн хэмжээ буурах магадлалтай боловч энэ нь ОХУ манай экспортын уламжлалт бараануудаас авах татвараа аль хэр багасгахаас шууд шалтгаалах юм.

Монгол улс, ОХУ-ын худалдааг ерөнхийд нь авч үзвэл Монгол улсын экспортын барааны нэр төрөл урьдынхаасаа эрс цөөрч улам бүр түүхий эдийн шинж чанартай болсон тул манай гадаад худалдааны тэнцэл бараг жил дараалан алдагдалтай гарч урсгал өр өссөөр 2007 оны байдлаар 2 тэрбум 588,6 сая ам. долларт хүрээд байна. Монголын экспортод ОХУ-ын эзлэх байр суурь буурч байгаа ч импортод тэргүүлэх байртай хэвээр төдийгүй, бензин, дизелийн түлш, цахилгаан эрчим хүч, сэлбэг хэрэгсэл, химийн зарим материалын хувьд Монгол улс хэт хамааралтай, энэ нь эдийн засгийн эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлсээр байна. Энэ бүгд нь Монгол улсаас ОХУ-тай хийж буй гадаад худалдааны үр ашиг хангалтгүйн дээр энэ байдлыг өөрчилж хоёр талдаа харилцан ашигтайгаар худалдаагаа цаашид өргөжүүлэн хөгжүүлэх гарцаагүй шаардлагатай байгааг харуулж байна. ОХУ-тай хийж буй худалдаа тогтмол алдагдалтай байгааг өөрчлөхийн тулд манай улс экспортынхоо эх үүсвэрийг олшруулан худалдаалах хэмжээг нь нэмэгдүүлэхээс өөр аргагүй. Тиймээс мал аж ахуйн гаралтай түүхий эд, баялаг, газрын хөрсөн доорх болон гадарга дээрх баялгуудаа эдийн засгийн эргэлтэнд оруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.